ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 02 өдөр Дугаар А/03 Улаанбаатар хот

Үндсэн цалин, нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, Улсын Их хурлын 2019 оны "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай" 21 дүгээр тогтоол, 2022 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 487 дугаар тогтоол, "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 488 дугаар тогтоолын 3, 5 дугаар хавсралт, Журамд өөрчлөлт оруулах тухай 491 дүгээр тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1649 дүгээр захирамж, Газрын дүрмийн 7.1.1, Хөдөлмөрийн дотоод журмын 6.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн хэмжээ, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг хавсралт ёсоор баталсугай.

2.Албан хаагчдын цалингийн хэмжээ, албан тушаалын ангилал, зэрэглэл, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг хавсралтад заасан хувь, хэмжээгээр тооцож 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн олгохыг Ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/31 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА С.ТӨМӨРДУЛАМ

9022011029
3314551 СБТ17629

d:\hotiin_standart\2023_b_tushaal_blank.docx

1150500009